БАТЛАВ.

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
САНГИЙН ЗАХИРАЛ Ш.ЭНХПҮРЭВ

УЛААНБААТАР ХОТ
ТЕХНОЛОГИЙН САН
АТА3415 9126813
9019120050

ТӨР, ХУВИЙН ХЭВШЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ СУДАЛГАА ХӨГЖҮҮЛЭЛТИЙН ТӨСЛИЙН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЖ БУЙ ҮР НӨЛӨӨГ ТОДОРХОЙЛОХ, ДҮГНЭЛТ ГАРГАХ СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР

Зорилго:

Судалгааны зорилго нь төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлж, дүгнэлт гаргахад чиглэнэ.

Эрхзүйн үндэслэл

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”-ын “Шинжлэх ухаан, инновац” хэсгийн 2.4 дэх зорилтод “Олон улсад өрсөлдөх чадвар бүхий үндэсний шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог хөгжүүлнэ.” гэж тодорхойлсон.

Энэхүү зорилтын хүрээнд 2021-2030 оныг “Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлэх”, улмаар 2030 он гэхэд “Мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор судалгаа хөгжүүлэлт, инновацын санхүүжилтийн олон эх үүсвэрт тогтолцоо бүхий төр-шинжлэх ухаан-үйлдвэрлэл, бизнесийн түншлэлийн таатай орчныг бүрдүүлэх, мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бий болгох, цаашлаад чадварлаг эрдэмтдийг бэлтгэх үндэсний тогтолцоог бий болгох замаар олон улсын томоохон судалгаанд оролцох боломжийг нэмэгдүүлсэн байх”-аар тусгасан.

Дээрх урт, дунд хугацааны хөгжлийн бодлогод туссан зорилт, арга хэмжээний хүрээнд 2024 онд Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийг шинэчлэн батлахын зэрэгцээ Засгийн газрын 2022 оны 409 дүгээр тогтоолоор “Төрийн өмчит эрдэм шинжилгээний хүрээлэн, төвийн судалгааны үндсэн чиглэлийг тогтоох, санхүүжүүлэх журам”, 497 дугаар тогтоолоор “Шинжлэх ухаан, технологийн сангаас тэтгэлэг олгох, сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг тус тус баталсан нь шинжлэх ухаан, технологийн судалгаа хөгжүүлэлтийг илүү өргөн хүрээнд авч үзэх, мөн санхүүжилтийн олон төрөл хэлбэрээр дэмжих, судалгаа хөгжүүлэлтийн санхүүжилт, чанар хүртээмж, үр өгөөжийг дээшлүүлэх, судалгаа хөгжүүлэлтийн нийгэм эдийн засаг, шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг илүү тодотгох, ингэснээр судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар иргэдийн амьдралын чанарыг сайжруулах хэрэгцээ шаардлагыг бий болгож байна.

Иймд өнөөдрийн нөхцөл байдалд дүгнэлт хийж, төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох нь чухал юм.

Судалгааны хамрах хүрээ, хийгдэх ажил:

Төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлж, дүгнэлт гаргах судалгааны ажлыг дараах агуулгын хүрээнд хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн өнөөгийн нөхцөл байдал, хүчин зүйлсийн нөлөөллийг тодорхойлох;
   - Төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох;
   - Олон улсын түвшинд төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг судлах.
2. Төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлох, дүгнэлт гаргах;
   - Төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөө, нөлөөлж буй хүчин зүйлс, параметрүүдийг тодорхойлох;
   - Судалгааны үр дүнд үндэслэн дүгнэлт гаргах;
   - Цаашид авч хэрэгжүүлэх бодлого, шийдлийг зөвлөмжлөх.

Судалгааны ажлыг гүйцэтгүүлэх хугацаа:

- Гэрээ байгуулсанаас хойш 45 хоногийн дотор хийж дуусган хүлээлгэх өгөхөөр төлөвлөх

Судалгааны ажлыг гүйцэтгэх чадавх, туршлага:

- Байгууллагын гэрчилгээ;
- Байгууллагын болон судалгааны багийн танилцуулга (Багийн ахлагч, гишүүдийн CV, холбогдох баримт бичиг);
- Ижил төстэй бодлогын судалгааны ажил, зөвлөх үйлчилгээ гүйцэтгэж байсан туршлагын мэдээлэл;
- Судалгааны ажлыг гүйцэтгэх ажлын төлөвлөгөө;
- Судалгааны ажлыг гүйцэтгэх санхүүгийн санал, задаргаа

Судалгааны ажлын хүлээгдэж буй үр дүн

Төр, хувийн хэвшлийн байгууллагын хэрэгжүүлж буй судалгаа хөгжүүлэлтийн төслийн шинжлэх ухаан, технологийн хөгжилд үзүүлж буй үр нөлөөг тодорхойлж, дүгнэлт гаргах судалгааны ажлын тайлан

---oOo---